



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2023 ОНЫ НАМЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 10 ДУГААР САРЫН 17-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ТҮР ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 10 дугаар сарын 17-ны өдөр, Мягмар гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	0
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	3-4
<hr/>	
<i>1.Горимын санал</i>	3-4

Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы Хянан шалгах түр хороо /Эмийн үнийн өсөлтийн шалтгаан, нөхцөлийг хянан шалгах/-ны 10 дугаар сарын 17-ны өдөр /Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл

Хянан шалгах түр хорооны дарга Ж.Чинбүрэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 7 гишүүнээс 4 гишүүн хүрэлцэн ирж, 57.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 16 цаг 25 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Жаргалмаа, Ц.Туваан.

Түр хорооны дарга Ж.Чинбүрэн Хянан шалгах түр хорооны хянан шалгагч томилох учраас хуралдааныг хаалттай явуулах горимын санал гаргав.

Ж.Чинбүрэн: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4

Татгалзсан: 0

Бүгд: 4

100 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул 16 цаг 31 минутад хуралдааныг хаалттай горимд шилжүүлэв.

Нээлттэй хуралдаан 6 минут үргэлжилж, 7 гишүүнээс 5 гишүүн хүрэлцэн ирж, 71.4 хувийн ирцтэйгээр 16 цаг 31 минутад өндөрлөв

Тэмдэглэлтэй танилцсан:

ХЯНАН ШАЛГАХ ТҮР
ХОРООНЫ ДАРГА

Ж.ЧИНБҮРЭН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 10 дугаар сарын 17-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Их засаг” танхим
16 цаг 26 минут.

ТҮР ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ж.Чинбүрэн: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Улсын Их Хурлын 2023 оны 60 дугаар тогтоолоор байгуулагдсан эмийн үнийн өсөлтийн шалтгаан нөхцөлийг хянан шалгах үүрэг бүхий Хянан шалгах түр хорооны гишүүдийн ирц бүрдсэн тул Түр хорооны 2023 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Ирцээ танилцуулъя. Жаргалмаа гишүүн, Туваан гишүүн нар гадаад томилолттой байгаа. Сандаг-Очир гишүүн одоо Хууль зүйн байнгын хорооны хурал дундуур гарч ирж бүртгэлдээ оръё гэсэн. Бусад бүх гишүүд хүрэлцэн ирсэн байна. Өнөөдөр хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Эмийн үнийн өсөлтийн шалтгаан нөхцөлийг хянан шалгах үүрэг бүхий Хянан шалгах түр хорооны хянан шалгагчийг томилж, ажлын даалгаврыг батална аа.

Хэлэлцэх асуудлын талаар саналтай гишүүд байна уу?

Бейсен гишүүн саналаа хэлье.

Б.Бейсен: Энэ тендерийн юмнууд байна шүү дээ. Эм ханган нийлүүлэх байгууллагууд энийг шалгах тал дээр бас оруулахгүй бол одоо ихэнх эмийн өсөлт энэ дээр байгаа шүү дээ. Нөгөө талаар

түрүүн би ярьсан гааль дээр 10 хувийн НӨАТ байгаа. Ханган нийлүүлэх байгууллага дээр одоо 10 хувийн НӨАТ байгаа. Аптек өнөөдөр 10 хувийн НӨАТ, энийг чөлөөлсөн тохиолдолд бараг 30 хувь болчих гээд байна шүү дээ. Зарим одоо эмийн үнийн өсөлт бол нэлээн одоо сум дээр бүр ч өндөр байгаа юм.

Энэ асуудал дээр тэр эм ханган нийлүүлэх байгууллагыг шалгах гадаадаас орж ирж байгаа яг импорттоор хэдээр оруулж ирж байна. Гаалийн мэдээлэл яг гаалиар орж ирж байгаа үнийн дүнг нь бас авах хэрэгтэй. Энэ талыг бас шалгах тал дээр юм оруулсан нь зөв байх гэж бодож байна.

Ж.Чинбүрэн: Бейсен гишүүнд баярлалаа.

Энэ хэлэлцэх асуудал бид нар одоо нөгөө хянан шалгагчаа томилчихоод ажлын даалгавар өгөхдөө энэ асуудлаа оруулъя.

Тэгэхлээр та их зөв зүйл хэлж байна. Энэ ялангуяа энэ тендертэй холбоотой асуудал дээр дээрээс нь энэ үнэ өсөж байгаа бид нарын гол одоо учир шалтгааныг судлах учраас гааль болон тэгээд энэ татварууд нэмэгдэж байгаатай холбоотой ер нь бодитоор яаж нэмэгдэж байна гэдгийг бид бүр нэг бүрчлэн үзэх хэрэгтэй юм. Тэр дотроо энэ зайлиггүй шаардлагатай эм дотор энэ одоо улсаас худалдан авч байгаа эм дотор хэр зэрэг өртөг нь нэмэгдэж байна гэдгийг бид бүүр зайлиггүй үзэх ёстой. Бид нарын гол ажил учраас энэ юуныхаа ажлын даалгавар дотроо энийгээ оруулаад ярьчихъя.

Тэгэхлээр хэлэлцэх асуудал орж байна гэсэн үг. Санал нэг байна уу? Та Бейсен гишүүний микрофоныг нээнэ үү?

Б.Бейсен: Тэр эмийн тендерийн асуудал байна даа. Жил болгон хотын клиникийн эмнэлгүүд, аймгийн нэгдсэн эмнэлгүүд, сумын эмнэлгүүдийн эрүүл

мэндийн одоо юу эмийн төсвийн асуудал байгаа тийм үү. Тендер шалгаруулалт дээр энийг нарийн шалгахгүй бол яг хилээр тийм юмаар оруулж ирчхээд тэгээд өндөр үнээр зараад байгаа байхгүй юу. Энэ зохион байгуулалттай энэ өсөлтийн асуудал байж байгаа. Зарим эм эмнэлгийн хэрэгслийн асуудал ч байж байгаа. Энийг яг одоо бүр одоо нарийн шалгах нь зөв байх. Хөтөлбөртөө оруулаад.

Ингээд хаалттай горимд шилжье
ээ.
16:31 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ П.МЯДАГМАА

Ж.Чинбүрэн: Ойлголоо тэгэхлээр бид нөгөө ажлын даалгавар дотроо энэ улсын өмчлөлтэй эмнэлгүүдийн тендерийн асуудлыг оруулъя гэдгээр нэлээн тийм онцгой энэ дээр анхаарал хандуулж даалгавар дотроо баталъя гэдэг саналаа хэлж байна. Өөр саналтай гишүүд байхгүй бол хэлэлцэх асуудлаа ингээд тохирлоо.

Түр хорооны хянан шалгагч нарыг томилох тухай тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Түр хорооны хянан шалгагч шинжээч томилох нь Түр хорооны дотоод асуудал бөгөөд Хянан шалгах түр хорооноос томилогдсон ажиллахад хянан шалгах, шинжээч нарт хөндлөнгөөс нөлөөлөх магадлалтай учраас хаалттай хуралдаж томилох горимын саналыг гаргаж байна аа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2, 12.3 дахь хэсгийг тус тус үндэслэн хуралдааныг хаалттай горимд шилжүүлэх горимын саналаар санал хураалт явуулъя аа.

Хаалттай явуулъя гэдэг дээр саналаа өгнө үү.

Гишүүдийн 100 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Хуралдааныг хаалттай горимд шилжүүлнэ үү.